

“МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН ХАРЪЯА БОР-ӨНДӨР УБУ-ИЙН НЕФЪТ АГУУЛАХЫН ӨРГӨТГӨЛИЙН АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

	Ажил гүйцэтгэх үндэслэл	1.1. "Монголпросцветмет" Төрийн өмчит үйлдвэрийн газар (ТӨҮГ)-ын 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр
2	Барилга байгууламжийн байршил	2.1. Монгол улс, Хэнтий аймаг, Бор-Өндөр сум, "Бор-Өндөр" Уулын баяжуулах үйлдвэр (УБУ)
3	Хийгдэх ажил, шаардагдах гол тоног төхөөрөмж, байгууламжууд	<p>3. Захиалагчийн батлуулсан зураг төслийн дагуу хийж гүйцэтгэнэ. Үүнд:</p> <p>3.1. "Бор-Өндөр" УБУ-ийн Материал техник хангамжийн хэлтэс (МТХХ)-ийн харъяа Шатах тослох материал (ШТМ)-ын агуулахад байрлах 400 м3-ийн 1 ширхэг босоо ган савыг буулгаж дизелийн түлш хадгалах зориулалт бүхий 700м³-ийн багтаамжтай ил босоо ган сав 2 ширхэг, ослын 25м³ багтаамжтай далд ган сав 1 ширхэг тоноглолийн хамт иж бүрэн байрлуулах. Босоо 700м3-ийн савыг бүрэн автомат гагнуураар гагнасан байх буюу суурилуулалтын ажилд мөн бүрэн автомат гагнуураар гагнаж ажлыг гүйцэтгэх /Гагнуурын төрөл - Automatic submerged arc welding machine/. Мөн босоо савны хананы 1-р үеийг зориулалтын зэврэлтээс хамгаалах будгаар будах, савны шалыг бүтэн зэврэлтээс хамгаалах будгаар будах. Саванд хуулируулагч хийх. Тус ажлыг гүйцэтгэх хугацаанд нефьт агуулахын ажиллагааг зогсоохгүй 400м3-ийн 2 ширхэг босоо ган савнууд байнгын түлштэй байх тул аюулгүй ажиллагааг бүрэн хангаж, тооцоолон ажиллах.</p> <p>3.2. Вагон цистернээс дизелийн түлш буулгах насос 3 ширхэгийг шинээр суурилуулах, 120м³/цаг хүчин чадалтай байх.</p> <p>3.3. Автоцистернд дизелийн түлш ачих төхөөрөмж шинээр суурилуулах (насос 2 ширхэг, 60-90м³/цаг хүчин чадалтай).</p> <p>3.4. - Вагонцистернээс дизелийн түлш буулгах төхөөрөмж-зогсоол - 3 ширхэг - Автоцистернд дизелийн түлш ачих төхөөрөмж-зогсоол - 2 ширхэгийг шинээр байгуулах.</p> <p>3.5. Автоцистернд дизелийн түлш ачих зогсоолын саравч (3м * 24м * Н6м) - 1 ширхэгийг шинээр зургийн дагуу барих.</p> <p>3.6. Дээрх барилга болон байгууламжуудыг батлагдсан зураг төсвийн дагуу хийх / "УБУ-ийн байгууллагын дотоод хэрэгцээний ГТБА өргөтгөл шинэчлэлт" батлагдсан зургийн дагуу/</p> <p>3.7. Гүйцэтгэгч байгууллага савны баталгаажуулалтыг стандартын дагуу хийлгэж бичиг баримтыг бүрдүүлэн барилга байгууламжийн хамт хүлээлгэн өгөх.</p>
		4.1. Дизелийн түлшийг вагонцистернээс насосоор соруулан ил босоо ган сав руу юулж, хадгалан, автоцистернд насосоор ачина.
4	Хийгдэх ажил. Технологийн	4.2. Барилга байгууламжийн бүрэлдэхүүн хэсэг: Шатах тослох материалын агуулахын барилга (одоо ашиглагдаж байгаа ба үүнд нярав байрлах өрөө, цахилгаан тоноглол-цитны өрөө, вагоноос шатахуун буулгах насосны өрөө, жижиг савлагаатай тос-тосолгооны материал хадгалах өрөө, ариун цэврийн өрөө гэх мэт) /одоо байгаа барилгын

<p>горим, барилга байгууламжийн бүрэлдэхүүн</p>	<p>хэмжээ 12,5м * 28,0м/ зургийн дагуу, объектыг сэргээн засварлах.</p> <p>4.3. 400м³ -ийн багтаамжтай ил босоо ган сав 1 ширхэгийг буулгаж, шинээр 2 ширхэг 700м³ -ийн багтаамжтай ил босоо ган савыг барих. Босоо 700м³-ийн савыг бүрэн автомат гагнуураар гагнасан байх буюу суурилуулалтын ажилд мөн бүрэн автомат гагнуураар гагнаж ажлыг гүйцэтгэх /Гагнуурын төрөл - Automatic submerged arc welding machine/</p> <p>4.4. 700м³ багтаамжтай ил босоо ган сав (ШТМ-ын агуулахад байгаа 400м³ багтаамжтай 1 ширхэг ил босоо ган савны суурин дээр) 2 ширхэг байх бөгөөд савны суурь, түлшний шугам хоолой болон галын шугам хоолой, холбох хэрэгсэл, тоноглолын хамт шинээр хийх. Мөн ослын 25м³ багтаамж бүхий далд ган сав 1 ширхэгийг тоноглолын хамт, мөн зургийн дагуу бусад байгууламжуудыг шинээр хийх.</p> <p>4.5. Дизелийн түлшний савны паркийн бетон суурь, шороон далан болон хашлага шинээр хийх /ус зайлуулах сувагтай байх/.</p> <p>4.6. Технологийн шугам хоолой, хаалт, арматурууд ил монтажлагдана.</p> <p>4.7. Дизелийн түлшийг вагонцистернээс буулгах болон автоцистернд ачих бетон талбайг шинээр барих. /Зургийн дагуу/</p> <p>4.8. Дизелийн түлшийг буулгах болон ачих насосууд нь шинэ хүчин чадал саванд тохирсон байх.</p> <p>4.9. Дизелийн түлшийг вагонцистернээс буулгах иж бүрэн төхөөрөмж - 3 ширхэг /Шинэ хүчин чадал байгууламжид тохирсон байх/</p> <p>4.10. Дизелийн түлшийг автоцистернд ачих төхөөрөмжийн арал шинээр хийх - 2 ширхэг</p> <p>4.11. Аянга зайлуулагч, газардуулга /цайрдсан/ ШТМ-ын агуулахад тавигддаг стандартын дагуу шинээр хийх</p> <p>4.12. Гадна болон дотоод цахилгаан хангамж байгууламж барих /гадна гэрэлтүүлэг, цахилгааны бусад монтаж тооцоогоор/.</p> <p>4.13. Босоо савны гал унтраах болон усан хөргөлтийн технолгийн байгууламж барих. Мөн галын усан сан хийгдсэн байх /стандартын дагуу шинээр хийх/</p> <p>4.14. Галын анхан шатны багаж хэрэгслийн сарай, тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу хийх.</p> <p>4.15. Ууршуулах бетон талбай шинээр хийх.</p> <p>4.16. Гадна тохижилт, стандартын бие засах газар барих (гадна 2 суудалтай /эр, эм/).</p> <p>4.17. Одоо ашиглаж буй 400м³ багтаамж бүхий савны суурин дээр шинээр байрлуулах 700м³ багтаамж бүхий сав, шугам хоолой болон түлш буулгах, ачих төхөөрөмжүүдийг монтажлан ашиглалтад оруулах үеийн ажлыг гүйцэтгэхдээ ШТМ-ын агуулахын хэвийн ажиллагааг тасалдуулахгүй байхаар тооцож ажиллах.</p> <p>4.18. Тоног төхөөрөмж, сав, шугам хоолойн болон аянга зайлуулагчийн газардуулга хийх зураг тооцооллын дагуу.</p> <p>4.19. Дээр дурдагдсан ажлууд болон барилга бүтээц, гадна холбоо дохиолол, гадна цахилгаан, гэрэлтүүлэг, галын усан сан, савнуудын суурь, савнуудын угсралт суурилуулалт,</p>
---	--

		савны далан, шат тавцан, тос хадгалах саравч, харуулын байр, насосны станцын барилга, автоцистернд ачих төхөөрөмжийн саравч, вагонестакадын шат тавцан шинээр хийх ажлуудыг батлагдсан зургийн дагуу гүйцэтгэх.
5	Ажиллах горим	5.1. Үйлдвэрлэлийн тасралтгүй хэвийн ажиллагааг хангах зориулалтаар шатахуун хүлээн авах, түгээх үйлчилгээг 8 цагаар тооцож хийх. Бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэх хугацаанд 400м3-ийн 2 ширхэг босоо сав байнгын түлштэй байх тул аюулгүй ажиллагааг бүрэн хангаж, тооцоолон ажиллах.
6	Гадна инженерийн шугам сүлжээ	6.1. Гадна цахилгаан хангамж төлөвлөх. Үүнд: түлш ачих төхөөрөмж, хашаа болон талбайн гэрэлтүүлэг, хүчний тоног төхөөрөмжүүдийн цахилгаан монтаж
		6.2. Гадна бохир ус – талбайн бохир ус зайлуулах болон галын систем, ууршуулах талбай хийх
7	Өргөтгөлийн ажил гүйцэтгэх байгууллага	7.1. Тусгай зөвшөөрөл бүхий компани /ШТМ-ийн барилга байгууламж байгуулах, босоо сав угсрах эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй/ байх.
		7.2. Дадлага туршлагатай байх /өмнө нь энэ төрлийн ажил үйлчилгээ хийж байсан/
8	Ажил гүйцэтгэх хугацаа	8.1. Гэрээ байгуулснаас хойш 9 сарын дотор
9	Онцгой нөхцөл	9.1. Галын аюулаас урьдчилан сэргийлэх, ГХХ болон техникийн аюулгүй ажиллагаа, ариун цэвэр эрүүл ахуй, байгаль орчныг хамгаалах шаардлагуудын холбогдох хууль, тогтоомж стандарт, БНБД-ийн дагуу бүрэн төлөвлөж хийх.
		9.2. Гал, техникийн аюулгүй ажиллагааны санамж, дохио тэмдэг, сурталчилгааны самбар, шатахууны төрөл тэмдэглэгээ, техник хэрэгслийн байгууллагын стандартын дагуу хийх.
		9.3. Газрын тосны бүтээгдэхүүний тухай, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль болон Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандартуудын техникийн шаардлагыг хангасан байна.
		9.4. Байгаль, цаг уурын өөрчлөлтийг тооцож хийх.
		9.5. Байгууллагын стандарт, өнгө будгийн дагуу барилга байгууламжуудыг байгуулах.

10	<p>Шатах тослох материалын агуулахын өргөтгөлийн ажил гүйцэтгэхэд мөрдөх шаардлага стандартууд</p>	<ol style="list-style-type: none"> 1. “Авто тээврийн хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2003 2. “Аж ахуй нэгж байгууллагын, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага” MNS 5566:2005 3. “Аюултай ачааны ангилал. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4978:2007 4. Байгаль орчны сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын 2007 оны 151/126/52 дугаар тушаал. Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах, журам 5. “Барилга байгууламжийн аянга хамгаалалтын зураг төсөл зохиох заавар” БД 43-103-08 6. “Барилга байгууламжийн гал унтраах автомат тоног төхөөрөмж, дохиололын хэрэгсэл” 7. “Барилга байгууламжийн галын аюулгүй байдал” БНБД 21.01.02 8. “Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хуулийн 11.1-д заасан, газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах” гэсэн хуульд нийцсэн байх. 9. “Барилга байгууламжийн тэсрэх ба шатах аюулын ангилал тогтоох” НПБ 105-95 10. “Гадаад тоноглолын галын аюулын ангилал тогтоох” НПБ 107-97 11. “Гал түймрээс хамгаалах нийтлэг стандарт” MNS:13.220.01 12. “Нефть бүтээгдэхүүн тээвэрлэх ба түгээх тээврийн авто хэрэгсэл. Төрөл, хэмжээгдэхүүн ба техникийн нийтлэг шаардлага” ГОСТ 50913-96 13. “Төмөр хоолойн түгжээч арматур. Түгжээний битүү байдлын норм” ГОСТ 9544-93 14. “Ус хангамж. Гадна шугам сүлжээ ба байгууламж” БНБД 40-02-84 15. “Цахилгаан байгууламжийн дүрэм” БД 43-101-03 16. Хими, нефть хими болон нефть боловсруулах салбарын үйлдвэрлэлд статик цахилгаан хамгаалалтын дүрэм 17. “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30-01 04 18. “Монголросцветмет” ТӨҮГ-ын захиалгаар “Ай Пи Жи Ди Инженерг” ХХК-ийн гүйцэтгэсэн ЕГ Шифр:14/2023, Магадлалын дүгнэлтийн нэгтгэлийн бүртгэлийн 1656/2023 дугаартай “Бор-Өндөр УБҮ-ийн байгууллагын дотоод хэрэгцээний газрын тосны бүтээгдэхүүний агуулахын өргөтгөл, шинэчлэлт”-ийн ажлын зураг
----	--	--

Жич: Тендерт оролцогч нь Газрын тосны бүтээгдэхүүний агуулахын өргөтгөл, шинэчлэлийн ажлын болон загвар зураг, ажлын төсөвтэй танилцах боломжтой.